



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/78/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	“Өндөрхаан итгэл аудит” ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	5
3.4 Материаллаг байдал	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
4. Аудитын илрүүлэлт	9
4.1 Залруулсан алдаа	9
4.2 Төлбөрийн акт	9
4.3 Албан шаардлага	9
4.4 Зөвлөмж	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

᠘᠐᠒᠒.᠐3.23 № 280

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

023030305

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Жаргалтхаан сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,764,166.00	49,458,060.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	16,950.00	234,409.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	16,950.00	234,409.00
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	41,747,216.00	49,223,651.00
351	Түүхий эд материал	-	-
35130	Эм боох материал	-	-
354	Хангамжийн материал	41,747,216.00	49,223,651.00
35410	Бичиг хэргийн материал	1,263,600.00	1,559,200.00
35420	Аж ахуйн материал	6,891,025.00	7,252,700.00
35440	Тулш, шатах тослох материал	-	155,652.00
35450	Барилгын засварын материал	-	2,817,700.00
35460	Хүнсний материал	533,160.00	1,501,968.00
35470	Бусад хангамжийн материал	33,059,431.00	35,936,431.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	467,286,832.08	451,832,247.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	467,286,832.08	451,832,247.50
392	Биет хөрөнгө	455,476,832.08	440,022,247.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	434,542,490.00	434,542,490.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,142,892.64)	(33,203,641.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,241,530.00	47,781,330.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,259,746.32)	(28,173,205.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,362,717.85	28,362,717.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,605,608.43)	(18,466,212.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	630,910.00	1,630,910.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(285,811.92)	(445,384.54)
39217	Ном	7,993,243.54	7,993,243.54
393	Биет бус хөрөнгө	11,810,000.00	11,810,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,810,000.00	11,810,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	509,050,998.08	501,290,307.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,000,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,000,000.00	-
413	Өглөг	5,000,000.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	5,000,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	5,000,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	504,050,998.08	501,290,307.50
51	Засгийн газрын хувь оролцоо	504,050,998.08	501,290,307.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	115,246,536.00	115,246,536.00
51101	Өмч: - төрийн	115,246,536.00	115,246,536.00
512	Хуримтлагдсан үр дүн	322,155,595.40	319,394,904.82
51210	Өмнөх үеийн үр дүн	322,155,595.40	322,155,595.40
51220	Тайланг үеийн үр дүн	-	(2,760,690.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,648,866.68	66,648,866.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	509,050,998.08	501,290,307.50

Жаргалтхаан сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	346,802,800.00	288,828,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,288,500.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	69,288,500.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,288,500.00	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69,288,500.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	277,514,300.00	287,828,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	246,752,300.00	246,856,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	246,752,300.00	246,856,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	108,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,762,000.00	40,863,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,762,000.00	40,863,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	279,653,824.89	291,589,590.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	279,653,824.89	291,589,590.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,783,961.19	269,699,594.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,686,598.15	179,738,138.96
210101	Үндсэн цалин	138,374,592.15	153,094,367.96
210102	Нэмэгдэл	20,768,606.00	14,068,141.00
210104	Урамшуулал	10,893,400.00	9,570,166.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,650,000.00	3,005,464.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,607,756.15	23,277,573.04
210201	Тэтгэврийн даатгал	14,801,608.82	15,917,043.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,720,581.38	1,756,116.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,373,104.27	1,441,022.82
210204	Ажигүйдийн даатгал	337,496.52	355,237.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,374,965.16	3,808,152.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,899,949.00	30,877,083.00
210301	Гэрэл, цахилгаан	3,323,811.00	1,933,249.00
210302	Түлц, халаалт	34,281,338.00	27,927,334.00
210303	Цэвэр, бохир ус	294,800.00	1,016,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,117,720.00	2,814,923.00
210401	Бичиг хэрэг	1,454,500.00	796,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,598,780.00	594,158.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	620,240.00	804,540.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	365,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,079,200.00	379,625.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	17,726,071.00	11,286,439.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	227,600.00	161,200.00
210502	Хоол, хүнс	16,316,571.00	11,125,239.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,181,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	384,800.00	667,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	140,000.00	-
210604	Урсгал засвар	244,800.00	667,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	652,000.00
210702	Дотоод албан томилолт	-	652,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,037,066.89	20,385,937.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,107,381.36	1,391,553.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,929,685.53	18,994,384.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,869,863.70	21,889,996.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	489,351.00	1,517,617.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	489,351.00	1,517,617.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,080,512.70	20,072,379.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,080,512.70	20,072,379.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	67,148,975.11	(2,760,690.58)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	67,148,975.11	(2,760,690.58)

Жаргалтхаан сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	115,246,536.00	66,648,866.68	322,155,595.40	504,050,998.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,246,536.00	66,648,866.68	255,006,620.29	436,902,022.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	67,148,975.11	67,148,975.11
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	115,246,536.00	66,648,866.68	322,155,595.40	504,050,998.08
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	115,246,536.00	66,648,866.68	322,155,595.40	504,050,998.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,246,536.00	66,648,866.68	322,155,595.40	504,050,998.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,760,690.58)	(2,760,690.58)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	115,246,536.00	66,648,866.68	319,394,904.82	501,290,307.50

Жаргалтхаан сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	277,933,991.00	287,828,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	277,933,991.00	287,828,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	246,752,300.00	246,856,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	246,752,300.00	246,856,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	108,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,762,000.00	40,863,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,762,000.00	40,863,400.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	419,691.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	419,691.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	277,933,991.00	287,828,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,933,991.00	287,828,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,644,436.30	265,938,904.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,651,346.00	180,042,650.00
210101	Үндсэн цалин	115,547,082.00	115,994,990.00
210102	Нэмэгдэл	33,731,693.00	40,140,829.00
210104	Урамшуулал	13,059,846.00	14,150,131.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,312,725.00	9,756,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,647,099.30	23,190,521.00
210201	Тэтгэврийн даатгал	14,776,856.52	16,054,785.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,717,511.46	1,759,419.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,374,308.71	1,451,660.81
210204	Ажилгүйдлийн даатгал	343,202.75	356,786.80
210205	Эрүүл мэндийн даатгал	3,435,219.86	3,567,868.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,272,649.00	35,860,583.00
210301	Гэрэл, цахилгаан	3,236,911.00	1,933,249.00
210302	Түлц, халаалт	26,740,938.00	32,927,334.00
210303	Цэвэр, бохир ус	294,800.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,329,620.00	4,241,350.00
210401	Бичиг хэрэг	1,712,000.00	120,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,598,780.00	749,810.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	707,140.00	804,540.00
210404	Ном, хэвлэл	787,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	365,000.00	348,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,159,200.00	2,218,400.00
2105	Нормативт зардал	20,806,022.00	12,651,247.00
210501	Эм, бөлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	227,600.00	52,600.00
210502	Хоол, хүнс	14,579,022.00	12,094,047.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,999,400.00	504,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,899,400.00	3,485,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,899,400.00	-
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	-	3,485,200.00
2107	Томилголт, зочны зардал	-	652,000.00
210702	Дотоод албан томилголт	-	652,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,714,300.00	5,815,353.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,714,300.00	5,715,353.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,289,554.70	21,889,996.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	719,691.00	300,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	419,691.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	489,351.00	1,517,617.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,080,512.70	20,072,379.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Жаргалтхаан сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, гүүнтэй адилагдах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	287,720,300.00	266,130,304.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,720,300.00	266,130,304.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,420,300.00	265,830,304.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,335,200.00	180,042,650.00
210101	Үндсэн цалин	115,614,100.00	115,994,990.00
210102	Нэмэгдэл	38,691,000.00	40,140,829.00
210104	Урамшуулал	14,153,700.00	14,150,131.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,876,400.00	9,756,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,747,500.00	23,190,521.00
210201	Тэтгэврийн даатгал	17,215,000.00	16,054,785.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,883,100.00	1,759,419.61
210203	ҮОМШО-ний даатгал	1,506,500.00	1,451,660.81
210204	Ажилгүйдлийн даатгал	376,600.00	356,786.80
210205	Эрүүл мэндийн даатгал	3,766,300.00	3,567,868.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,378,200.00	35,860,583.00
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	1,933,249.00
210302	Түлш, халаалт	32,378,200.00	32,927,334.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,434,900.00	4,132,750.00
210401	Бичиг хэрэг	93,500.00	120,000.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	749,810.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,075,800.00	804,540.00
210404	Ном, хэвлэл	57,200.00	-
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,218,400.00	2,218,400.00
2105	Нормативт зардал	24,307,500.00	12,651,247.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,600.00	52,600.00
210502	Хоол, хүнс	23,750,300.00	12,094,047.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	504,600.00	504,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,485,200.00	3,485,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	3,485,200.00	3,485,200.00
2107	Томилголт, зочны зардал	677,600.00	652,000.00
210702	Дотоод албан томилолт	677,600.00	652,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура	-	-
210802	Аудит, багалгаажуулалт, зэрэглэл тогтоох		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,054,200.00	5,815,353.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,800.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,915,400.00	5,715,353.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	287,720,300.00	266,130,304.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	246,856,900.00	226,784,521.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	246,856,900.00	226,784,521.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,863,400.00	39,345,783.00
132001	Орон нутгийн төсвөөс	40,863,400.00	39,345,783.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХ	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-

Жаргалтхаан сумын цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ тогрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	108,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	108,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	108,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	108,600.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	108,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	108,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	108,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор П.Мөнгөнтуул, аудиторын туслах Ж.Батсайхан нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоос.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 279,653.8 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 2,796.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,237.2 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,760.7 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	17.00	234.40	217.40
Урьдчилгаа			-
Бараа материал	41,747.20	49,223.70	7,476.50
Үндсэн хөрөнгө	467,286.80	451,832.20	(15,454.60)
Нийт хөрөнгө	509,051.00	501,290.30	(7,760.70)
Өр төлбөр	5,000.00		(5,000.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	504,051.00	501,290.30	(2,760.70)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	115,246.50	115,246.50	-
Хуримтлагдсан үр дүн	322,155.60	322,155.60	=
Тайлант үеийн үр дүн		(2,760.70)	(2,760.70)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,646.90	66,646.90	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	509,051.00	501,290.30	(7,760.70)

Авлага 217.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь 49,223.7 мянган төгрөг болж 7,476.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 21,517.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 14,084.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, аж ахуйн материал 323.7 мянган төгрөгөөр, барилгын засварын материал 2,817.7 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 2,877.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 451,832.2 мянган төгрөг болж 15,454.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 18,994.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогдсонтой холбоотой.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 319,394.9 мянган төгрөг болж, 2,760.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгийн бууралт нөлөөлсөн байна.

Урьд оны 5,000.0 мянган төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 57,973.9 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй авсан орлого 68,288.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 11,935.8 мянган төгрөгөөр буюу 4,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл нэмэгдэл цалингийн зардал 8,051.5 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 1,669.9 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 448,691.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 160,970.4 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 287,720.3 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалингийн зардлыг 73,895.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 8,562.4 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 798.2 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 39,733.5 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 287,720.3 мянган төгрөгөөр баталсанаас 246,856.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 40,863.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 246,856.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 40,863.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 266,130.3 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 20,072.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 1,517.6 төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

ХЭА-2022/78/НА-СТА-ТШЗ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 266,130.4 мянган төгрөг буюу 92.5 хувьтай байгаа нь гэрэл цахилгааны зардлыг 1,933.2 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 2,292.6 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 11,656.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 108.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд оруулбал зохих 144 мэдээллийг байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 удаагийн 234.4 мянган төгрөгийн авлагыг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж, өгсөн зөвлөмж байхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,577.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,539.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,037.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Илрүүлэлт

4.3.1 Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2,539.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

4.4.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 803.1 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Илрүүлэлт:

4.4.2. Тайлант онд оруулбал зохих 144 мэдээллийг байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 удаагийн 234.4 мянган төгрөгийн авлагыг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Жаргалтхаан сумын Цэцэрлэг	2	3,342.9					1	2,539.8	1	803.1
	Дүн	2	3,342.9					1	2,539.8	1	803.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Жаргалтхаан сумын цэцэрлэг	1	234.4							1	234.4
	Дүн	1	234.4							1	234.4
	Нийт дүн	3	3,577.3					1	2,539.8	2	1,037.5



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 227/23910610
ХЭА 2022/78/НА ЕТН ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2,539.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалтхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч С.Алтанцэцэг, нягтлан бодогч Г.Урансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Б.МАНАЛСҮРЭН

Д.ОЮУНТУЯА

